



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/345

Зуунмод

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хүний эрхийг хангах чиглэлээр аймгийн Хүний эрхийн салбар хороо”-ны 2022 оны нэгдсэн төлөвлөгөө”-г нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д, зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, аймгийн Хүний эрхийн салбар хорооны хуралд тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

